



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/555

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд Төгрөг суманд байгуулж буй хүлэмжийн цогцолборын усалгаанд шаардагдах 25 тн ус нөөцлөх сав худалдан авахад 10,000,000 (арван сая), Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан тогооч нарын “Ур чадварын уралдаан”-нд орон нутгаас оролцогчдын шатахууны зардалд дэмжлэг үзүүлж 1,700,000 (нэг сая долоон зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 11,700,000 (арван нэгэн сая долоон зуун мянга) төгрөгийг “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 1108

D:My Doc. Zahiramj. Zasag darga